



Сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад багш нарт тулгасан асуудлыг CBAM загвараар судалсан үр дүн

Жаргалсайханы Дэнсмаа 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Халтарын Энхжаргал 

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Ноокоогийн Оюунцэцэг 

Монгол Улсын Их Сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Дэнсмаа, Ж., Энхжаргал, Х., Оюунцэцэг, Н. (2025). Сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад багш нарт тулгасан асуудлыг CBAM загвараар судалсан үр дүн. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 30(2). <https://doi.org/10.56380/mjer.v30.2.4>

Results of a study using the CBAM model on the challenges faced by teachers during curriculum implementation

Densmaa Jargalsaikhan 

Mongolian National Institute for Educational Research,

Enlkjargal Khaltar 

Mongolian National Institute for Educational Research

Nookoo Oyuntsetseg 

Mongolian National Institute for Educational Research

To cite this article:

Jargalsaikhan, D., Khaltar, E., Nookoo, O. (2025). Results of a study using the CBAM model on the challenges faced by teachers during curriculum implementation. *Mongolian Journal of Educational Research*, 30(2). <https://doi.org/10.56380/mjer.v30.2.4>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад багш нарт тулгасан асуудлыг CBAM загвараар судалсан үр дүн

Жаргалсайханы Дэнсмаа, Халтарын Энхжаргал, Ноокоогийн Оюунцэцэг

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2025.10.01

Засаж сайжруулсан: 2025.11.10

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2025.11.17

Түлхүүр үг:

Сургалтын хөтөлбөр

Туршилт

Санаа зовоосон асуудал

ХУРААНГУЙ

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2024-2025 оны хичээлийн жилд бага боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг боловсруулах, турших ажлыг зохион байгуулсан билээ. Энэхүү өгүүллээр бага боловсролын сургалтын хөтөлбөр, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг турших явцад бага ангийн багш нарын санаа зовнисон асуудлыг CBAM (санаа зовнисон асуудалд суурилан хэрэгжүүлэх загвар) ашиглан судалсан үр дүнг танилцуулж байна. Судалгаанд нийслэл, орон нутгийн нийт 24 ерөнхий боловсролын сургуулийн 101 бага ангийн багш, 31 сургалтын менежер, БШУГ-ын мэргэжилтэн хамрагдсан. Судалгааны үр дүнгээс харахад багш нарын хамгийн их санаа зовнисон нь мэдээллийн (75.2), хувийн (75.9), ажил үүргийн (54.4), хамтын ажиллагааны (65.4) үе шатууд байна. Энэхүү судалгаагаар инновацыг нэвтрүүлэх, тэр дундаа боловсролын салбарт инновацыг амжилттай хэрэгжүүлэхэд CBAM-ыг ашиглах, оролцогч талуудын санаа зовнисон асуудлыг ойлгох, түүнд тулгуурлан мэргэжлийн хөгжилд нь дэмжлэг үзүүлэх, олон талт хамтын ажиллагааг төлөвлөхөд үр дүнтэй болохыг харуулсан.



Энэхүү өгүүлэл нь *Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0* Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Ж.Дэнсмаа

Монгол Улсын Боловсролын Их сургууль, Боловсрол судлалын сургууль

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Email: densmaa@mier.mn

Results of a study using the CBAM model on the challenges faced by teachers during curriculum implementation

Densmaa Jargalsaikhan, Enlkjargal Khaltar, Nookoo Oyuntsetseg

Article information

Article history:

Received: Oct 01, 2025

Revised: Nov 10, 2025

Accepted: Nov 17, 2025

Keywords:

curriculum

pilot

concern

ABSTRACT

In accordance with the action plan for the renewal of the pre-primary and general education curricula and textbooks, the development and pilot testing of the primary education curriculum and instructional materials were organized during the 2024–2025 academic year. This article presents the results of a study examining the concerns of primary school teachers during the pilot testing of the primary education curriculum, student handbooks, and workbooks, using the CBAM (Concerns-Based Adoption Model) framework. The study involved a total of 101 primary school teachers, 31 vice-principals of primary education from 24 schools in the capital city and rural areas and specialists from the Department of Education. The results of the study show that teachers' highest levels of concern are concentrated in the Stages of Concern related to Information (75.2%), Personal (75.9%), Management/Task (54.4%), and Collaboration (65.4%). This study demonstrated that using CBAM to introduce innovation, particularly to successfully implement innovation in the education sector, is effective for understanding the concerns of stakeholders, providing professional development support based on those concerns, and planning for diverse collaboration.



This is an open access article under the *Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License*.

Corresponding author:

J.Densmaa

Mongolian National University of Education, Mongolian National Institute for Educational Research

Email: densmaa@mier.mn

УДИРТГАЛ

Олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлага, өөрийн улсын хөгжлийн бодлоготой уялдуулан “Монгол суралцагч”-ийн хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг түвшин бүрээр залгамж холбоотой боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх хүний нөөц болон сургалтын орчныг бүрдүүлэх шаардлага байна (Итгэл нар, 2024). Энэхүү шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн Газраас суралцагчийн эзэмших чадамжийг тодорхойлж, түүнийг эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэх “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”-ыг баталсан (МУЗГ, 2024). Тус үзэл баримтлалд нийцүүлж бага боловсролын сургалтын хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэхэд ашиглах сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг боловсруулах, турших, тохирцыг шалгах ажил 2024-2025 оны хичээлийн жилд хийсэн.

Энэ удаа сургалтын хөтөлбөр, сурагчийн галын авлага, дасгал ажлын дэвтрийг боловсруулан туршиж байгаагаараа онцлог байна.

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх зорилтууд:

- Суралцагчийн эзэмших ерөнхий болон суурь чадамжийг хөгжүүлэх;
- Чадамжийг суралцахуйн хүрээ, боловсролын түвшин, шатлал, анги бүрээр залгамж холбоотой тодорхойлох;
- Суралцагчийн хүрэх үр дүн (суралцахуйн үр дүн)-ээр агуулгын залгамж холбоо тодорхойлох;
- Багш төвтэй арга зүйгээс татгалзаж, суралцагч төвтэй конструктивист онолд суурилж боловсруулах;
- Суралцагчийн өдөр тутмын амьдрал, хөгжилд ач холбогдолтой, сонирхолтой сургалтын идэвхтэй арга зүйг баримтлах;
- Суралцагчийн эзэмших чадамжаар тодорхойлсон хэмжигдэхүйц шалгуураар үнэлэх
- Судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөрт заавал тусгах нийтлэг агуулгыг тодорхойлсон.

Сургалтын хөтөлбөр нь багшлахуй, суралцахуйн төвд “суралцагч” байх, тэдэнд мэдлэгийг тулгах биш, харин түүнийг бүтээхэд дэмжлэг үзүүлэх тохиромжтой орчин бүрдүүлэх, хамтын үйл ажиллагаанд чиглүүлэх, суралцахуйг идэвхтэй сургалтын аргаар зохион байгуулах “үүрэг”-ийг багш нарт өгч байна (Gökçek, 2009). Ихэнхдээ эдгээр ойлголт нь багш нарын хувьд “шинэлэг” байдаг тул сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ багш нар өөрсдийн үүргийг шинэ дүр төрхөөр харах шаардлагатай болж байна. Гэвч сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь багшаас юу шаардаж байгааг ойлгох, тохирох хариу арга хэмжээ авах нь тэдэнд хялбар биш байж болох юм.

Хэрэгжилт гэдэг нь төлөвлөсөн хөтөлбөр (intended curriculum)-ийг сургалтын үйл явц болгон бодит байдалд хэрэгжүүлэх, хичээл заах идэвхтэй үйл явцыг хэлнэ. Энэ нь "хэрхэн" гэсэн асуултад хариулагдах бөгөөд сургалтын хөтөлбөрийг практикт хэрэгжүүлэх үйл явц юм. Төлөвлөсөн хөтөлбөр нь суралцагчийн юу сурахыг тодорхойлдог бодлого, удирдамж бөгөөд мөн багшлахуй, суралцахуйг хэрхэн дэмжихийг багтаасан байдаг. Харин ангид бодитоор юу зааж байгааг онцолдог нь хэрэгжүүлсэн хөтөлбөр (implemented curriculum) бөгөөд төлөвлөсөн хөтөлбөрийг бодит байдалд хэрхэн хэрэгжүүлж байгаад анхаарал хандуулдаг. Үүнд багш юу зааж байгаа, багшийн өөрийн онцлог (ур чадвар, туршлага ...), мөн тэдний заах арга зүй, орчин, хэрэглэгдэхүүний хүртээмж зэргийг багтаана. Эцэст нь суралцагч бодитоор юу сурсныг хэмждэг нь хэрэгжсэн хөтөлбөр (attained curriculum) юм. Энэхүү загвар нь сургалтын хөтөлбөрөөр юу хүлээж, юу зааж, юу үнэлж байгааг бүхэлд нь авч үзэх шаардлагатайг харуулж байна (Зураг 1).




Зураг 1. TIMSS Curriculum Model, 2019.

Төлөвлөсөн сургалтын хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөр өөрөөр хэлбэл багшлахуй, суралцахуйн бодит үйл явц, практикт шилжихэд багш чухал үүрэгтэй. Анги танхимд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь багш бөгөөд багшгүйгээр түүнийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй (Nnabuike at all, 2016). Иймд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн үүрэг их. Хэрэгжүүлсэн хөтөлбөр буюу бодит хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг бууруулахгүйгээр багш сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, суралцагчид амжилттай үр дүнд хүрэхэд хүндрэл учирч болзошгүй (TIMSS, 2015). Сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад багш нарын санаа зовнисон асуудлыг тодорхойлох, багшид шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох нь чухал байдаг.

Энэхүү судалгааны хүрээнд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшид тулгарч буй асуудлыг тодорхойлох, цаашид үндэсний түвшинд нэвтрүүлэхэд анхаарах арга замыг судлах зорилго дэвшүүлсэн

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Энэхүү судалгаанд Холл, Уоллес, Доссет (1973) нарын боловсруулж, Холл, Лорд (1987, 2011) нарын хөгжүүлсэн санаа зовнисон асуудалд суурилан хэрэгжүүлэх загвар (Concerns-Based Adoption Model, цаашид СВАМ гэх)-ыг ашигласан. СВАМ нь боловсролын өөрчлөлтийг ойлгох, ялангуяа хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд өргөн хэрэглэгддэг загвар юм. Тус загварыг боловсролын өөрчлөлт (инновац)-ийг хэрэгжүүлэхэд үүрэг гүйцэтгэдэг хүмүүсийн түүнийг даван туулах үйл явцыг судлахад ашигладаг. Зураг 2-т үзүүлсэн өөрчлөлтийг чиглүүлэгч нь СВАМ загварын гол хүчин зүйл бөгөөд өөрчлөлтөд оролцож буй хувь хүмүүс (хэрэглэгч) эсвэл бүлгийн хэрэгцээнд үндэслэн үйл ажиллагаа зохион байгуулагчид юм. Тэд хэрэглэгчийг өөрчлөхөд туслах нөөцийн системтэй байдаг. Ямар нөөцийг хэзээ, хэрхэн ашиглах нь “санаа зовнисон асуудалд суурилсан оношилгоо”-нд тулгуурладаг. Өөрчлөлтийг чиглүүлэгч нь хувь хүмүүс болон бүлгийн хэрэгцээг оношлохын тулд “асуудлын үе шат, хэрэглээний түвшин, инновацын тохиргоо”-г хийж болно. СВАМ загвар нь өөрчлөлтийг чиглүүлэгч нь оношилгооны мэдээллээр үйл явцыг хөнгөвчлөхийн тулд нөөцийг хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргаж, хэрэглэгчид хөндлөнгөөс нөлөөлөх боломжтойг харуулдаг. Аливаа өөрчлөлтийн үйл явцын хамгийн чухал хүчин зүйл бол түүнд оролцогчид юм. Өөрчлөлтийг чиглүүлэгчид эсвэл түүнийг нэвтрүүлэх байгууллага нь чухал боловч өөрчлөлт (инновац)-ийг хэрэгжүүлэгч (хэрэглэгч)-ийн хувьд хоёрдогч нь байдаг.



Зураг 2. Санаа зовнисон асуудалд суурилан хэрэгжүүлэх загвар Concern Based Adoption Model)


СВАМ-ийн асуудлын үе шат (SoC) нь өөрчлөлтийг хэрэгжүүлж буй хэрэглэгчийн санаа зовоосон асуудалд төвлөрдөг (Hall, 1979). SoCQ нь тухайн хэрэглэгч өөрчлөлтийн ямар үе шатанд байгааг тодорхойлох үндсэн хэрэгсэл юм. Судалгаагаар хэрэглэгчдэд тулгардаг 7 төрлийн санаа зовоосон асуудлыг тодорхойлсон. Эдгээр асуудлыг СВАМ загварт санаа зовнилын асуудлын үе шат гэж авч үздэг. Хэрэглэгч ямар ч үед бүх шатанд тодорхой хэмжээний санаа зовнилтой байж магадгүй ч өөрчлөлтийн хэрэгжилт ахих тусам санаа зовнилын асуудал нь өөр өөр байна гэдгийг судалгаагаар баталгаажуулсан байдаг. Эдгээр үе шатны өөрчлөлт нь хэрэглэгчийн санаа зовнисон асуудлын хөгжлийг илтгэдэг. Санаа зовнисон асуудлын хөгжлийг өөрийн, ажил үүргийн, үр нөлөөний гэсэн гурван хэмжигдэхүүн, долоон үе шатаар бүлэглэдэг. Хүснэгт 1-д санаа зовнисон асуудлын үе шат бүрийн товч тайлбарыг үзүүлэв.

Хүснэгт 1. Санаа зовнисон асуудлын үе шатны тайлбар

Асуудлын үе шат (SoC)	Санаа зовнисон асуудлын тайлбар (Expressions of Concern)
Үр нөлөөний (Impact)	6 Надад илүү сайн ажиллах ямар нэг зүйлийн талаар зарим санаанууд байна.
	5 Би инновацын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд бусадтай хүчин чармайлтаа зохицуулахыг хүсэж байна.
Ажил үүргийн (Task)	4 Миний хэрэглээ суралцагчдад хэрхэн нөлөөлж байна вэ?
	3 Би материалаа бэлтгэхэд хамаг цагаа зарцуулж байх шиг байна.
Өөрийн (Self)	2 Үүнийг ашиглах нь надад хэрхэн нөлөөлөх вэ?
	1 Би энэ талаар илүү ихийг мэдэхийг хүсэж байна.
Асуудалгүй (Санаа зовнилгүй) (Unconcerned)	0 Би үүнд санаа зовохгүй байна.

Багш нарын санаа зовнисон асуудлыг тодорхойлсноор бодлого боловсруулагчид (өөрчлөлтийг чиглүүлэгч) өөрчлөлтийг цаашид хөнгөвчлөх асуудлыг шийдэж чадна. Тодруулбал, сургалтын хөтөлбөрийн туршилт (инновац)-ыг хэрэгжүүлэхэд туршигч багш нарт тулгарч буй “санаа зовнисон” асуудлыг илрүүлэн, тэдэнд дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлох юм.

SoCQ (Stages of Concern Questionnaire) нь тухайн хувь хүн (хэрэглэгч) инновацын ямар үе шатанд байгааг тодорхойлох үндсэн хэрэгсэл бөгөөд 35 асуултаас бүрдэнэ. Энэ нь оролцогчдын санаа зовниж буй асуудлын төрөл, үе шатыг тоон болон графикаар дүрслэн харуулдаг олон тооны масштабтай асуулга юм (Newhouse, 2001). Судалгаанд оролцогчид санаа зовниж буй асуудал бүр нь тэдний хувьд хэр зэрэг үнэн болохыг илтгэн 0-7 хүртэлх тоогоор тэмдэглэнэ. Тоо нь их байх тусам санаа зовнисон асуудалтай, харин бага байх тусам санаа зовнисон асуудалгүйг илэрхийлнэ. 0 нь маш бага санаа зовнисон асуудалтай эсвэл огт санаа зовдоггүй буюу хамааралгүйг илтгэнэ. 0-7 хүртэлх тоог хэрэглэгч бүр (бүлэг)-ийн хувийн оноонд шилжүүлж, тухайн хэрэглэгч (бүлэг)-ийн профайлыг дүрсэлдэг. Профайлд дүн шинжилгээ хийх нь оролцогчдын санаа зовнисон асуудлыг тайлбарлах боломж олгодог.



Зураг 3. Санаа зовнисон асуудлын профайл

Хувь хүмүүс инновацийн талаар бага мэдлэгтэй, хэрэглээгүйгээс ашиглаж эхлэх, улмаар илүү боловсронгуй хэрэглээ рүү шилжихийн хэрээр тэдний санаа зовнисон асуудал тодорхой үе шатуудаар дамждаг. Тэд 0, 1, 2 дугаар үе шатанд санаа зовниж эхэлдэг бөгөөд дараа нь 3 дугаар үе шат руу шилжиж, эцэст нь 4, 5, 6 дугаар шатанд хамгийн их санаа зовнисон асуудлаа бүртгэдэг. Хэрэв инновацийг тохиромжтой сайн боловсруулсан, түүнийг хэрэгжүүлэхэд хангалттай дэмжлэг байгаа бол хувь хүний санаа зовнил нь цаг хугацааны явцад Зураг 3-д үзүүлсэн шиг (туршлагатай эсвэл шинэчлэгдэж буй хэрэглэгч) харагдана гэж үзнэ.

Боловсролын салбарт шинэ сургалтын хөтөлбөр, арга зүй, инновацийг үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэх үйл явцыг ойлгох, удирдах, дэмжихэд түгээмэл ашигладаг бөгөөд үүнд голлох оролцоотой багшийн хэрэгцээ, хандлагад төвлөрдөг. Тухайлбал, Турк улс сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн эхний жилд математикийн багш нарын санаа зовнилыг судлахдаа энэхүү загварыг ашигласан бөгөөд үр дүнд багш нар мэдээллийн, хувь хүний, менежментийн шатанд хамгийн их санаа зовниж, үр дагаврын шатанд хамгийн бага санаа зовнилтой байгааг илрүүлж, багшийн өөрийнх нь уламжлалт арга барил болон шинэ сургалтын хөтөлбөрийн хоорондын зөрчилдөөнөөс бэрхшээл үүсдэгийг тодорхойлжээ (Gokcek at al., 2018). Гана улсын дунд сургуулийн ICT хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй 346 багшийн санаа зовнисон асуудлыг СВAM загварын ашиглан үнэлсэн бөгөөд судалгааны үр дүнд багш нарын санаа зовнисон асуудлын үе шатууд нь тэдний багшлах туршлагатай холбоогүйг илрүүлжээ. Багш нарын санаа зовнисон асуудлын “хувийн” үе шат нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй гэж үзжээ (Sarfo at al., 2017). Хятад улсын ахлах сургуулийн англи хэлний шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжилтийг СВAM ашиглан судалсан судалгааны үр дүнгээс багш нар хөтөлбөрийн талаар эерэг үзэл бодолтой боловч удирдлагын, хувийн, үр дагаврын үе шатанд санаа зовнисон асуудалтай тулгардаг. Тодруулбал, сургуулийн тоног төхөөрөмж, удирдлагын дэмжлэг зэрэг хэрэгжилтийг дэмжих янз бүрийн эерэг хүчийн зүйлийг тодорхойлсон. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтэд саад учруулж буй сөрөг хүчин зүйл, тухайлбал, үндэсний англи хэлний шалгалтын тодорхойгүй байдал, багш нарын бэлтгэл хангалтгүй зэрэг хүчин зүйлсийг тодорхойлсон бөгөөд Хятадын боловсролын шинэчлэлийн хүрээнд багшийн өөрчлөлтийг судлахад хэрэг болохуйц СВAM загварыг үнэлжээ (Wang, 2013). Гана улсын судлаач өөрийн улсын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх СВAM-ийн давуу болон сул талыг тодорхойлсон. Тэрээр 2000-2024 он хүртэлх хугацаанд хэвлэгдсэн 32 судалгааны өгүүлэлд дүн шинжилгээ хийж, СВAM нь багш нарын санаа зовнисон асуудлыг ойлгох, тэдэнд мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжихэд үр дүнтэй болохыг харуулсан. Харин тухайн улс орны хэл, соёл, нөөцийн онцлогт тохируулан өөрчлөх шаардлагатайг тодотгожээ (Avedzi, 2025).

АРГА ЗҮЙ*Оролцогчид:*

Судалгаанд бид туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн 24 сургуулийн 1-5 дугаар ангийн 101 багш, 24 сургалтын менежер, тухайн орон нутгийн БШУГ-ын 7 мэргэжилтнийг хамруулсан. Тэд 2024-2025 оны хичээлийн жилийн 1 ба 2 дугаар улиралд бага боловсролын 9 судлагдахууны туршилтын сургалтын хөтөлбөр, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг нийслэлийн 7, аймгийн төвийн 8, сумын төвийн 9, нийт 24 ерөнхий боловсролын сургуульд туршсан.

Сургалтын хөтөлбөрийн туршилтыг “өөрчлөлт”, туршигч багш, сургалтын менежер, мэргэжилтнийг “хэрэглэгч” гэж үзвэл SoCQ нь өөрчлөлтийг чиглүүлэгч (судлаач, бодлого боловсруулагч, зохион байгуулагч)-д сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, туршилтын зохион байгуулалт, менежментийн талаар багшийн санаа зовнисон асуудлыг үнэлнэ. Туршилтын явцад багшийн санаа зовнисон асуудлыг илрүүлж, тэдгээрийг шийдвэрлэснээр туршилтыг амжилттай удирдан чиглүүлнэ. Багш 101, сургалтын менежер 24, мэргэжилтэн 7, нийт 131 судалгаанд оролцогчдын хүйс, байршил, ажилласан жил, мэргэжлийн зэрэг гэх мэт мэдээллийг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

		Багш (%)	Сургалтын менежер (%)	Мэргэжилтэн (%)
Хүйс	Эмэгтэй	83.2	100	57.1
	Эрэгтэй	16.8	-	42.9
	Сум	36.6	41.7	-
Байршил	Аймаг	32.7	29.2	85.7
	Нийслэл	30.7	29.	14.3
	0-5 жил	21.8	-	14.3
	6-10 жил	25.7	4.2	28.6
Ажилласан жил	11-15 жил	15.8	16.7	14.3
	16-20 жил	14.9	16.7	-
	20-оос дээш жил	21.8	62.5	42.9
	Зэрэггүй	29.7	-	42.9
Мэргэжлийн зэрэг	Заах арагч	38.6	20.8	14.3
	Тэргүүлэх	31.7	62.5	42.9
	Зөвлөх	-	16.7	-


Судалгааны хэрэгсэл

Судалгааны хэрэгсэл нь сургалтын хөтөлбөрийн туршилтад багш нарын санаа зовниж буй асуудлыг тодруулах зорилготой SoCQ (Hall et al. 1979) байв. Асуулгын хуудас нь А ба Б гэсэн хоёр хэсэгтэй. А хэсэгт багшийн нас, хүйс, багшаар ажилласан жил, мэргэжлийн зэрэг, сургуулийн байршил гэх мэт судалгаанд оролцогчдын талаарх үндсэн мэдээллийг багтаасан. Харин Б хэсэг нь сургалтын хөтөлбөрийн туршилтад багш нарт тулгамдаж буй асуудалтай холбоотой 35 асуултаас бүрдэнэ. Багшийн санаа зовнисон асуудлыг илрүүлэх асуултуудыг долоон ангилалд ангилсан (Хүснэгт 1). Ангилал тус бүр таван асуулттай бөгөөд ангилал дахь асуултуудыг хариултыг нэгтгэн оноог тооцоолсон. Өндөр оноо нь санаа зовнил их байгааг, бага оноо нь санаа зовнилгүй байгааг илтгэнэ. Асуултуудын үнэн зөвийг баталгаажуулахын тулд асуулгыг урьдчилан туршиж, шалгасан. Асуулгын найдвартай байдлыг Кронбахын альфа коэффициент тооцож шалгахад $\alpha = 0.89$ байна. Кронбахын альфа коэффициент 0.70 ба түүнээс дээш байвал найдвартай байдал хангалттай сайн гэж үздэг (Фрэнкель & Уоллен, 2000) бөгөөд нарын дээрх үзүүлэлт нь асуулгын найдвартай байдал сайн байгааг илтгэж байна. Боловсруулалтад нийт 132 өгөгдлийг оруулсан бөгөөд бодитой бус хариултыг илрүүлэх 0 вариацийн утгыг шинжилсэн.

ҮР ДҮН

Зураг 5-д туршилтын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлсэн бүх багшийн санаа зовнисон асуудлын профайлыг харуулав.


Үе шат 0-д бүх багшийн онооны дундаж 63.6 нь тэд туршилтын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарал хандуулахгүй байна гэж үзэж болно. Үе шат 0-ийн хувьд онооны дундаж 40-өөс доош бол дунд зэрэг, 75-аас дээш бол өндөр гэж үздэг (Gökçek, 2009). Онооны дундаж бага байх тусам тухайн багш



Зураг 4. Багшийн профайл (бүх багш)


туршилтын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд ач холбогдол өгч байгааг илтгэдэг. Харин үе шат 1 дэх бүх багшийн онооны дундаж 75.9 нь тэд сургалтын хөтөлбөрийн туршилтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсэж байгааг харуулж байна. Үе шат 2-ын онооны дундаж 75.2 нь туршилтын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлснээр багшийн мэргэжлийн өсөлтөд ямар нөлөө үзүүлэх талаар санаа зовниж байгааг илтгэж байна. Хувийн үе шатны санаа зовнил нь туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар болон өөрийн ажил үүрэгтээ эргэлзээтэй байгааг илтгэх хандлагатай байдаг. Үе шат 3 нь сургалтын хөтөлбөрийн туршилтын цаг хугацаа, менежмент, зохион байгуулалтад санаа зовж байгааг илтгэх ба харгалзах онооны дундаж нь Үе шат 1 ба 2-ын онооны дунджаас харьцангуй бага буюу 54.4 байна. Энэ нь багш нарт туршилтын менежментэд санаа зовнисон асуудал өмнөх 2 шатныхаас бага байгааг харуулж байна.

Харин 4 дүгээр үе шатанд багш нар хамгийн бага санаа зовнилтой байна (31.6). Тодруулбал, багш нар туршилтын сургалтын хөтөлбөрийн суралцагчдад үзүүлэх нөлөө, тэдний хөгжилд дэмжлэг үзүүлэх эсэхэд анхаарал хандуулахгүй буюу энэ талаар санаа зовнихгүй байна. Багш нарын санаа зовнисон асуудал ихтэй дараагийн үе шат 5 буюу хамтын ажиллагаа байна. Үе шат 5-д онооны дундаж өсөж, 65.4 болсон нь багш нар сургалтын хөтөлбөрийн туршилтыг хэрэгжүүлэхэд бусадтай хамтран ажиллах сонирхолтой байгааг харуулж байна. Энэ нь сургуульд тухайн судлагдахууны хөтөлбөр турших багш анги бүрд 1 байгаатай холбоотой байж болох юм. Энэ үе шатны асуултын багц нь бусадтай хамтран ажиллах, өөрийн туршлага, үр дүнгээ хуваалцахтай холбоотой. Үе шат 6-ийн онооны дундаж үе шат 5-ынхтай харьцуулахад бага байна (57.0). Энэ нь багш нарт туршилтын сургалтын хөтөлбөрөөс өөр, илүү сайн хөтөлбөр, хувилбар байхгүй гэж үзэж буйг илтгэнэ. Үе шат 6-ийн онооны дундаж нь багш нар сургалтын хөтөлбөрт одоогоор ямар нэгэн өөрчлөлт хийх талаар бодолгүй байгааг илтгэж байгаа бөгөөд энэ нь туршилтын сургалтын хөтөлбөрийг ашиглаад хагас жил зарцуулсан багшийн хувьд боломжийн үзүүлэлт гэж үзэж болно.




Зураг 5. Сургалтын менежер, мэргэжилтний профайл

Туршилтын сургуулийн сургалтын менежер болон тухайн орон нутгийн БШУГ-ын мэргэжилтнүүдийн санаа зовнисон асуудлын профайлыг Зураг 5-д үзүүлэв. Багш нартай харьцуулахад тэд Үе шат 0 буюу “анхаарал хандуулаагүй” түвшинд өндөр байна. Үе шат 1-д мэргэжилтнүүдийн онооны дундаж бусдаас өндөр буюу 85.7 байгаа нь тэд мэдээлэл авах хэрэгцээ ихтэй байгааг харуулж байна. Мөн мэргэжилтнүүдийн үе шат 3-ын онооны дундаж нь тэд бусад оролцогч талуудаас илүү туршилтын зохион байгуулалт, менежментэд санаа зовниж байгааг илтгэж байна. Харин сургалтын менежерийн үе шат 5-ын онооны дундаж бусад оролцогчдоос илүү байгаа нь тэд хамтран ажиллах сонирхол ихтэй байгааг харуулж байна. Бусад үе шатанд сургалтын менежер ба мэргэжилтнүүдийн санаа зовнилын түвшин багш нарынхтай ойролцоо байна.



Зураг 6. Багшийн профайл (байршлаар)

Зураг 6-д үе шат бүрд багшийн санаа зовнисон асуудлын профайлыг байршлаар харуулсан байна. Нийслэл, аймгийн төв, сумын төвийн багш нарын үе шат бүрд авсан онооны зөрөө харьцангуй бага, Зураг 5 дахь гарфикийн ерөнхий хэв маягтай ижил байна.



Зураг 7. Багшийн профайл (ажилласан жилээр)

Зураг 7-д үе шат бүрд багшийн санаа зовнисон асуудлын профайлыг ажилласан жилээр харуулав. Үе шат 0-д 11-15 дахь жилдээ ажиллаж буй багшийн онооны дундаж бага (45.2) байгаа нь тэд сургалтын хөтөлбөрийн туршилтын талаар бусдаасаа их анхаарал хандуулж байна. Харин Үе шат 1-д 16-20 дахь жилдээ ажиллаж буй багшийн онооны дундаж өндөр (82.6) байгаа нь тэд туршилтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсэж байгааг илтгэж байна. Зургаас 11-15 дахь жилдээ ажиллаж буй багш нарын үе шат бүрийн онооны дундаж нь бусдаасаа бага байгаа нь харагдаж байна. Энэ нь тус багш нар бусадтай харьцуулахад санаа зовнил бага байна гэсэн.


Хүснэгт 3. Багшийн профайл (судлагдахуунаар)

Судлагдахуун	Үе шат 0	Үе шат 1	Үе шат 2	Үе шат 3	Үе шат 4	Үе шат 5	Үе шат 6
Дүрслэх урлаг, дизайн	68.7	78.3	74.7	55.1	30.9	69.7	55.3
Хөгжим	53.9	79.1	71.9	47	26.9	55.4	57
Монгол хэл	60.4	82.6	77.8	55.1	36.3	74.3	60.9

Математик	54.8	83.9	79.4	52.9	32.4	75.1	62
Нийгмийн ухаан	64.1	67.8	73.6	52.5	33.9	64.4	52.5
Байгаль шинжлэл	75.3	85.8	83.8	65.7	34.4	68.3	68.5
Биеийн тамир	65.1	55.4	65.9	43.2	23.7	53.6	47.6
Тува хэл	40.6	63.4	67.4	37.2	21.6	49.4	30.8
Казах хэл	76	73.9	73.2	67.5	33.6	56.8	60.8

Хүснэгт 3-д үе шат бүрд багшийн санаа зовнисон асуудлын онооны дунджийг судлагдахуун бүрээр харуулав. Хүснэгтээс үе шат 0-д хамгийн бага оноо (40.6)-той судлагдахуун “Тува хэл”, хамгийн их оноо (75.3)-той судлагдахуун “Байгаль шинжлэл” байна. Тодруулбал “Тува хэл”-ний багш нар сургалтын хөтөлбөрийн туршилтад бусад судлагдахууны багш нараас илүү ач холбогдол өгч байгааг илтгэж байна. Харин “Байгаль шинжлэл”-ын багш нар бусад судлагдахууны багш нартай харьцуулахад туршилтын сургалтын хөтөлбөрт анхаарал бага хандуулж байна. Үе шат 1-д “Математик, Байгаль шинжлэл, Монгол хэл”-ний судлагдахууны багш нар бусад судлагдахууныхаас өндөр оноотой байгаа нь тэд сургалтын хөтөлбөрийн туршилтын талаар илүү мэдээлэл хүсэж байгааг харуулж байна. Харин “Байгаль шинжлэл” судлагдахууны багш нар өөрсдийн мэргэжлийн өсөлтийн талаар бусдаас илүү санаа зовниж байна. Сургалтын хөтөлбөрийн менежмент, зохион байгуулалтын талаар хамгийн их санаа зовниж байгаа нь “Казах хэл”-ний багш нар бол эсрэгээрээ санаа зовнил багатай нь “Тува хэл”-ний багш нар байна. Сургалтын хөтөлбөрийн туршилтын суралцагчдад ямар нөлөө үзүүлэх эсэхэд “Хөгжим, Биеийн тамир, Тува хэл”-ний багш нарын зовнил бусдаас бага байна. Харин “Математик, Монгол хэл”-ний багш нар туршилтын хугацаанд бусадтай хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа бусад судлагдахууны багш нараас илүү илэрхийлсэн байна.

Тухайн судлагдахууны туршилтын сургалтын хөтөлбөрийг нийслэл, аймгийн төв, сумын төвийн сургуулийн тэнцүү тооны багш нар хэрэгжүүлж буй тул бид үр дүнг байршлаар авч үзэх боломжтой. Бүх судлагдахууны хувьд үр дүнг тооцсон ч бид энэ удаа “Монгол хэл, Математик”-ийн судлагдахуунаар төлөөлөн харуулж байна (Зураг 4).



Зураг 8. Багшийн профайл (судлагдахуун, байршлаар)

Монгол хэлний судлагдахууны хувьд (Зураг ба) нийслэлийн болон сумын төвийн багш нар сургалтын хөтөлбөрийн туршилтад аймгийн төвийн багш нараас илүү ач холбогдол өгч байна. Нийслэлийн багш нар илүү мэдээлэл авах хүсэлтэй байна. Математикийн судлагдахууны хувьд (Зураг бб) сумын төвийн багш нар сургалтын хөтөлбөрийн туршилтад нийслэл болон аймгийн төвийн багш нараас илүү ач холбогдол өгч байна.

Багшийн санаа зовнилын үе шатуудын хоорондын хамаарлыг Хүснэгт 2-т харуулсан. Хүснэгтээс санаа зовнилын бүх үе шатуудын хоорондын хамаарал сайн байна. Тэр дундаа 1 ба 2 дугаар үе шатны хоорондын хамаарал .799** байгаа нь багшийг мэдээллээр сайн хангах тусам тэдний хувийн санаа зовнисон асуудал багасгахыг харуулж байна. Багшийн “мэдээллийн” шатны санаа зовнилыг багасгавал “хувийн” шатны санаа зовнил багасна. “Менежментийн” шатанд анхаарал хандуулж арга хэмжээ авснаар “анхаарал хандуулаагүй” багш нарын хувь буурна гэж үзэж байна.

Хүснэгт 4. Багшийн санаа зовнисон асуудлын профайлын үе шатуудын хоорондын хамаарал

		Үе шат 0	Үе шат 1	Үе шат 2	Үе шат 3	Үе шат 4	Үе шат 5	Үе шат 6
Үе шат 0	Pearson Correlation	1	.470**	.443**	.714**	.557**	.245*	.654**
	Sig. (2-tailed)		0.000	0.000	0.000	0.000	0.013	0.000
Үе шат 1	Pearson Correlation	.470**	1	.799**	.566**	.643**	.699**	.672**
	Sig. (2-tailed)	0.000		0.000	0.000	0.000	0.000	0.000
Үе шат 2	Pearson Correlation	.443**	.799**	1	.571**	.659**	.691**	.673**
	Sig. (2-tailed)	0.000	0.000		0.000	0.000	0.000	0.000
Үе шат 3	Pearson Correlation	.714**	.566**	.571**	1	.635**	.244*	.653**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000		0.000	0.014	0.000
Үе шат 4	Pearson Correlation	.557**	.643**	.659**	.635**	1	.561**	.661**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000		0.000	0.000
Үе шат 5	Pearson Correlation	.245*	.699**	.691**	.244*	.561**	1	.538**
	Sig. (2-tailed)	0.013	0.000	0.000	0.014	0.000		0.000
Үе шат 6	Pearson Correlation	.654**	.672**	.673**	.653**	.661**	.538**	1
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	

$P^* < 0.05$, $P^{**} < 0.01$, $P^{***} < 0.001$

СВАМ загварын үүднээс авч үзвэл хувь хүмүүс (хэрэглэгч) Үе шат 1, 2, 3-д санаа зовж буй асуудлаа шийдвэрлэсэн (багасгасан) үед л инновацыг амжилттай нэвтрүүлнэ. Хэрэв эдгээр үе шатанд санаа зовнисон асуудлууд их хэвээр байвал хэрэглэгч инновац ба инновацын хэрэглээг өөрчлөх эсвэл магадгүй ашиглахаа зогсооход бэлэн байдаг.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү өгүүлэлд Монгол улсын бага боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтын явцад туршигч багш нарын санаа зовнисон асуудлыг тодорхойлсон. Судалгаагаар санаа зовнисон асуудалд суурилан хэрэгжүүлэх загвар (СВАМ) нь инновац (сургалтын хөтөлбөр)-ийн багшид тулгарч буй асуудлыг оношилж, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход хэрэгцээтэйг олж тогтоосон. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогчдын санаа зовнисон асуудлын профайлыг ашиглан багшийн санаа зовнисон асуудалд суурилан янз бүрийн оролдлого (интервенц)-ыг хийснээр түүнийг инновацыг илүү сайн ашиглахад чиглүүлэх явдал юм (Hall & Hord, 2006, p. 142).

Цаашид сургалтын хөтөлбөр (инновац)-ыг нэвтрүүлэхэд багш (хэрэглэгч)-ийн санаа зовнисон асуудлыг илрүүлэх (оношлох), түүнийг багасгах талаар тохирсон арга хэмжээг зохион байгуулахад СВАМ загварыг ашиглах боломжтой. Боловсролд нэвтрүүлж буй инновацын хүрээнд багшийн өөрчлөлтийг тус загвар ашиглан судалж болох юм. Энэхүү судалгаа нь багшийн дадал, туршлагыг ойлгох, багш бэлтгэх үр дүнтэй хөтөлбөр боловсруулах, сургалтын хөтөлбөрийг цаашид амжилттай хэрэгжүүлэхэд суурь болно.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Энэхүү судалгаанд хамрагдсан багш, сургалтын менежер, мэргэжилтний тоо улсын хэмжээний багшийг бүрэн төлөөлөхөд хангалтгүй байж болно. Судалгаа нь зөвхөн 2024-2025 оны хичээлийн жилийн хугацаанд хийсэн бага боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтад явцын асуудал, бэрхшээлийг харуулсан. Тухайлбал, туршилтад сургуулийн I-V ангийн тус бүр нэг бүлгийн багш нар хамрагдсан нь тэдний “хамтын ажиллагааны” үе шатанд санаа зовнилын асуудал өндөр гарсан байж болно.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харахад багш нарын хамгийн их санаа зовнисон нь анхаарал хандуулаагүй (63.6), мэдээллийн (75.2), хувийн (75.9), ажил үүргийн (54.4), хамтын ажиллагааны (65.4) үе шатууд байна. Үе шат бүрд оноо өндөр байх тусам багш нарт санаа зовнисон асуудал их байгааг илтгэдэг.

Сургалтын хөтөлбөрийн туршилтад анхаарал хандуулаагүй, мэдээлэл дутуугаас үүдэн санаа зовнисон асуудалтай багш нар олон байна. Тэдэнд туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл хангалттай бус, туршилт хийх ач холбогдол, багшийн мэргэжлийн хөгжилд нь хэрхэн нөлөөлөх илүү дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй байна. Иймд багш нарт туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдэнд үзүүлэх мэргэжлийн дэмжлэг, заах арга зүй болон цаашид авах арга хэмжээг үргэлжлүүлэхэд баримталж буй бодлогыг тайлбарлах, таниулах шаардлагатай. Туршигч багш нарт өөр хоорондоо болон туршилтад оролцоогүй бусад багш нарт сургалтын хөтөлбөрийн туршилтын ач холбогдол, үр нөлөөг түгээн дэлгэрүүлэх болон тэднийг санал бодлоо солилцох, туршлагаа хуваалцах үйл ажиллагаанд хамруулах хэрэгтэй. Багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт сургалтын хөтөлбөрийн бүтэц, концепцийн талаар мэдээлэл өгөхөөс илүүтэй суралцахуйн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцагчийг хэрхэн үнэлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй байна. Тодруулбал, багш нарт “төлөвлөсөн хөтөлбөр”-ийг сургалтын анги танхимд бодитоор хэрэгжүүлэхэд суралцахуйг хэрхэн удирдан чиглүүлэх, заах арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн ямар байх гэх мэт “хэрэгжүүлсэн хөтөлбөр”-ийн талаар илүү тодорхой мэдээллийг өгөхөд анхаарна.

Багш нарын хамтын ажиллагааны үе шатны онооны дундаж өндөр байгаа тул тэднийг хөтөлбөрийг илүү сайн ашиглахад чиглүүлэхийн тулд бусад багш, сургуультай хамтран санал бодлоо хуваалцах, хэлэлцэх боломж олгох замаар энэ үе шатны онооны дунджийг багасгах хэрэгтэй. БШУГ-ын мэргэжилтэн, сургуулийн удирдлагууд бусад багш, сургуультай хамтран ажиллах, тэдэнд бэрхшээл тулгарсан үед шаардлагатай дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Тэднийг сургалтын хөтөлбөрийг илүү сайн хэрэгжүүлэхэд чиглүүлэхийн тулд бусад багш, эсвэл сургуулиудтай туршлагаа хуваалцах, хэлэлцэх боломжийг олгосноор багшийн хамтын ажиллагааны санаа зовнисон асуудал багасна.

Сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бодлого боловсруулагч болон мэргэжлийн байгууллагууд хэрэгжилтийн явцад багшийн санаа зовнисон асуудлыг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авах шаардлагатай. Үгүй бол сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн бүх хүчин чармайлт үр дүнгүй болно. Инновацыг нэвтрүүлэх, тэр дундаа боловсролын салбарт инновац (сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, цахим платформ гэх мэт)-ыг амжилттай хэрэгжүүлэхэд СВAM нь багшийн санаа зовнисон асуудлыг ойлгох, мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжихэд үр дүнтэй байхыг харуулсан.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны онолын хүрээг боловсруулахад мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан эрдэм шинжилгээний ажлын удирдагч багш М.Итгэл танд гүн талархал илэрхийлье. Мөн судалгаанд оролцож өөрийн цаг хугацаа, мэдлэг, туршлагаа хуваалцан туршилтад хамрагдсан нийслэл, аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, сургалтын менежер, мэргэжилтнүүдэд, мэдээлэл цуглуулахад хамтарч ажилласан БСҮХ-ийн сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтнуудад талархал илэрхийлье. Та бүхний оролцоо судалгааны үр дүнг боловсруулахад үнэтэй хувь нэмэр болсон.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: Н.О., Ж.Д.; **Арга зүй:** Н.О., Ж.Д.; **Мэдээлэл цуглуулалт:** Х.Э., Ж.Д.; **Бичилт (эхний хувилбар):** Ж.Д.; **Бичилт (засвар):** Ж.Д., Х.Э., Н.О.; **Нөөц:** Н.О., Х.Э.; **Мэргэжлийн удирдлага:** Н.О.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

УИХ. (2023). Боловсролын ерөнхий хууль. Монгол Улсын хууль. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

УИХ. (2023). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. Монгол Улсын хууль. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959012931>

- МУЗГ. (2024). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал. Монгол Улсын Засгийн Газрын тогтоол. Татаж авах холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781>
- Бэгз, Н. (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. УБ. Соёмбо принтинг ХХК.
- Пүрэв, О. (2021). *Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүй. III боть*. УБ. Мөнхийн үсэг ХХК.
- Оюунцэцэг, Н. (2023). *21 дүгээр зууны боловсрол: Насан туршийн суралцахуй*. УБ. Соёмбо принтинг ХХК.
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монголын боловсролын тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.1>

Гадаад хэлээр:

- Fullan, M. (1991). *The new meaning of educational change*. New York: Teachers College Press.
- George, A. A., Hall, G. E. & Stiegelbauer, S. M. (2006). *Measuring implementation in schools: The stages of concern questionnaire*, Southwest Educational Development Laboratory, Austin, TX.
- Hall, G. E. (1979). The concerns-based approach to facilitating change. *Educational Horizons*, 57(4), 202-208.
- Hall G., Hord, S., & Griffin, T. (1980, April). Making change happen: A case study of school district implementation. Paper presented at the Annual Meeting of the American Educational Research Association, Boston, MA.
- Hall, G. & Hord, S. (1987). *Change in schools: Facilitating the process*. Albany: State University Press.
- Newhouse, C. P. (2001). Applying the Concerns-Based Adoption Model to research on computers in classrooms, *Journal of Research on Technology in Education*, 33, 5, 1-21.
- Hall, G. E. & Hord, S. M. (2006). *Implementing Change: Patterns, principles and potholes*, Boston: Allyn and Bacon.
- Gokcek, T. (2009, January). How mathematics teachers' concerns changed within the context of curriculum reform?, *World Conference on Educational Sciences 2009. Procedia Social and Behavioral Sciences 1* (2009) 1052–1056
- Gokcek, T. & Baki, A. (2013). Turkish Mathematics Teachers' Concerns about the Curriculum Reform in the First Year of Implementation. *Eurasia Journal of Mathematics, Science & Technology Education*, 9(2), 177-190. DOI: 10.12973/eurasia.2013.928a. <http://dx.doi.org/10.12973/eurasia.2013.928a>
- Akwesi J.B (2012) Implementation, issues in secondary schools in Ghana. *Problems and prospects International Journal of Research Dev* 1(4) 546-574
- Nnabuikwe E.K., Aneke M.C., Otegbulu R.I (2016). Curriculum implementation and the teacher: issues, challenges and the way forward. *International Journal in Commerce, IT & Social Sciences*. Vol.03 Issue-06.
- Wenfeng Wang (2013, September). Teachers' Stages of Concern and Levels of Use of a Curriculum Innovation in China: A Case Study. *International Journal of English Language Teaching*. Vol.1, No.1; 2014. doi:10.5430/ijelt.v1n1p22. <http://dx.doi.org/10.5430/ijelt.v1n1p22>
- Sarfo, F. K., Amankwah, F., Baafi-Frimpong, S., & Asomani, J. (2017). Concerns of teachers about the implementation of information and communication technology curriculum in basic education in Ghana. *Contemporary Educational Technology*, 8(2), 103–118.
- Trapani, B., & Annunziato, A. (2019). Using the Concerns Based Adoption Model (CBAM) to accelerate Understanding by Design implementation. *Journal of Instructional Pedagogies*, 21, 1–12.
- Guskey, T. R. (1986). Staff development and the process of teacher change. *Educational Researcher*, 15(5), 5–12. <https://doi.org/10.3102/0013189X015005005>
- Avedzi, J. E. (2025). Examining the Concerns-Based Adoption Model: A systematic review of its strengths, weaknesses, and relevance to Ghana's standards-based and Common Core programme reforms. *Preprint*. <https://doi.org/10.21203/rs.3.rs-7310772/v1>
- Ramoutar-Bhawan, A. (2013). *Using the Concerns Based Adoption Model (CBAM) to evaluate teachers' concerns about the CAC in three primary schools in the Caroni Education District* (Unpublished master's project report). The University of the West Indies, St. Augustine Campus.
- Nevenglosky, E. (2018). *Barriers to effective curriculum implementation* (Doctoral dissertation, Walden University). ScholarWorks. <https://scholarworks.waldenu.edu/dissertations>

Зохногчдын мэдээлэл

Овог, нэр: Жаргалсайханы Дэнсмаа

 <https://orcid.org/0000-0002-2708-8415>

Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Хаяг: 302 тоот, МУБИС-ийн IX байр, Энхтайваны өргөн чөлөө-10, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Улс: Монгол

e-mail: densmaa@mnier.mn

Овог, нэр: Халтарын Энхжаргал

 <https://orcid.org/0000-0002-5076-6480>

Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Хаяг: 305 тоот, МУБИС-ийн IX байр, Энхтайваны өргөн чөлөө-10, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Улс: Монгол

e-mail: enkhjargal@mnier.mn

Овог, нэр: Ноокоогийн Оюунцэцэг

 <https://orcid.org/0009-0009-7796-5170>

Байгууллагын нэр: МУИС,

Хаяг: МУИС-ийн I байр, Их сургуулийн гудамж-1,

Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Улс: Монгол

e-mail: nookooyun@gmail.com
